МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160 0035
Утас: (976-11) 32 39 77, 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2024.07.25 № 01/4273

танай ________ -ны № ________ -т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Тодруулга оруулах тухай

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зарласан НЗДТГ/20240101013 дугаартай “Эрчим хүч хуримтлуурын станцын ажил”-ын тендер шалгаруулалтад оролцогчоос тодруулга авах хүсэлт ирсэнтэй холбогдуулан дараах тодруулгыг хавсралтаар оруулж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

Хавсралт 1 хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР

1110202123

| Д/д | Оролцогчийн тодруулга | Хариулт |
|---|---|---|
| 1 | Бид гадаадын үйлдвэрүүдтэй хамтран уг тендер шалгаруулалтад материал бэлдэж байгаа ба тендер шалгаруулалтын нээх эцсийн хугацаанд багтаан материал хүргүүлэхэд хэл орчуулгын асуудлаас эхлээд бэрхшээл учирч хугацаа их шаардаж байна. Бид та бүхнээс уг тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгах боломжтой эсэх талаар тодруулга авах хүсэлтэй байна. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6-д “Захиалагч тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж, цахим системд нийтэлсэн бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.” гэж заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгах боломжгүй. |